

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/131/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Назгүл
Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт.....	21
5.2 Албан шаардлага.....	21
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 10 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
К.ЕРКЕГҮЛ ТАНАА

2023.02.03 № 21
танай _____-ны № _____-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сургууль нь байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан, баталж ажиллаагүй байна.

Аудитын гол асуудал

Сургуулийн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалтгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

ЕБ-ын 10-р сургууль ДҮГНЭЛТ-2.02-ТА

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,883,240.00	108,430,962.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	81,014,486.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	81,014,486.00
3121	Төгрөг	-	81,014,486.00
31211	Төрийн сангийн харилцах	-	81,014,486.00
33	АВЛАГА	3,300,000.00	11,701,916.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		8,401,916.00
335	Бусад авлага	3,300,000.00	3,300,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,300,000.00	3,300,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,583,240.00	15,714,560.60
354	Хангамжийн материал	12,583,240.00	15,714,560.60
35470	Бусад хангамжийн материал	12,583,240.00	15,714,560.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,483,556,378.95	3,461,064,106.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,483,556,378.95	3,461,064,106.27
392	Биет хөрөнгө	3,454,985,316.49	3,434,617,668.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,495,048,697.00	3,495,048,697.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(94,487,271.84)	(181,706,292.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,974,000.80	56,996,432.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,011,875.75)	(9,965,836.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,735,000.00	62,983,736.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,883,072.92)	(11,034,781.20)
39217	Ном	18,609,839.20	22,295,712.20
393	Биет бус хөрөнгө	28,571,062.46	26,446,437.50

39301	Програм хангамж	8,674,500.00	8,674,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(559,437.54)	(2,684,062.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,456,000.00	20,456,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,499,439,618.95</u>	<u>3,569,495,068.87</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>16,023,827.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,023,827.00	-
413	Өглөг	16,023,827.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	11,776,047.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,247,780.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,483,415,791.95</u>	<u>3,569,495,068.87</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,483,415,791.95	3,569,495,068.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,456,000.00	20,456,000.00
51101	Өмч: - төрийн	20,456,000.00	20,456,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,462,959,791.95	3,549,039,068.87
51210	Өмнөх үеийн үр дүн	3,577,638,666.39	3,462,959,791.95
51220	Тайлант үеийн үр дүн	(114,678,874.44)	86,079,276.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,499,439,618.95</u>	<u>3,569,495,068.87</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	558,655,227.00	974,776,225.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,308,240.00	787,520.60
120	Нийтлэг татварын бус орлого	11,308,240.00	787,520.60
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	11,308,240.00	387,520.60
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,308,240.00	387,520.60
120009	Бусад орлого	-	400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	547,346,987.00	973,988,705.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	506,134,345.00	892,445,605.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	831,390,900.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	25,745,745.00	61,054,705.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	480,388,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,136,642.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,136,642.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,076,000.00	81,543,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,076,000.00	81,543,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	673,334,101.44	888,696,948.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	673,334,101.44	888,696,948.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	647,856,701.44	796,399,640.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	460,268,573.00	567,270,473.00
210101	Үндсэн цалин	418,901,973.00	417,884,211.00
210102	Нэмэгдэл		119,806,962.00
210104	Урамшуулал	32,026,900.00	29,579,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,339,700.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,409,300.00	66,634,156.00
210201	Тэтгэврийн даатгал	37,584,300.00	44,779,562.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,956,200.00	5,338,199.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,165,000.00	4,671,699.00
210204	Ажилгүйдлийн даатгал	791,300.00	1,168,099.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,912,500.00	10,676,597.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,331,026.00	35,570,398.00
210301	Гэрэл, цахилгаан	12,454,446.00	11,165,029.00
210302	Түлш, халаалт	16,876,800.00	23,405,736.00
210303	Цэвэр, бохир ус	3,999,780.00	999,633.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,617,200.00	-
210401	Бичиг хэрэг	590,700.00	

210402	Тээвэр, шатахуун	1,050,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	976,500.00	
2105	Нормативт зардал	21,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	458,700.00
210604	Урсгал засвар	-	458,700.00
2107	Томилолт, зочны зардал	-	400,000.00
210702	Дотоод албан томилолт	-	400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	503,000.00	4,342,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	103,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,342,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,706,602.44	121,723,913.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,748,136.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,753,144.00	6,526,464.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	93,953,458.44	103,449,313.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,477,400.00	92,297,308.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,477,400.00	91,985,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,477,400.00	75,032,850.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	16,952,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	311,958.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	311,958.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(114,678,874.44)	86,079,276.92
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(114,678,874.44)	86,079,276.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	521,601,242.00	913,334,000.00

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	400,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	400,000.00
120009	Бусад орлого		400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	521,601,242.00	912,934,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	480,388,600.00	831,390,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		831,390,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	480,388,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,136,642.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,136,642.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,076,000.00	81,543,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,076,000.00	81,543,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	516,676,244.00	812,417,178.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	516,676,244.00	812,417,178.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	491,198,844.00	720,119,870.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	395,624,400.00	587,448,434.00
210101	Үндсэн цалин	354,257,800.00	438,062,172.00
210102	Нэмэгдэл		119,806,962.00
210104	Урамшуулал	32,026,900.00	29,579,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,339,700.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,409,300.00	66,634,158.00
210201	Тэтгэврийн даатгал	37,584,300.00	44,779,562.92
210202	Тэтгэмжийн даатгал	3,956,200.00	5,338,199.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,165,000.00	4,671,699.41
210204	Ажилгүйдлийн даатгал	791,300.00	1,168,099.61
210205	Эрүүл мэндийн даатгал	7,912,500.00	10,676,597.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,776,000.00	39,818,178.00

210301	Гэрэл, цахилгаан	15,400,000.00	11,813,029.00
210302	Түлш, халаалт	16,376,000.00	23,405,736.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	4,599,413.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,862,000.00	-
210401	Бичиг хэрэг	144,300.00	
210402	Тээвэр, шатахуун	1,050,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	837,100.00	
210404	Ном, хэвлэл	329,800.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,800.00	
2105	Нормативт зардал	472,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,800.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	412,200.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	458,700.00
210604	Урсгал засвар	200,000.00	458,700.00
2107	Томилолт, зочны зардал	164,900.00	400,000.00
210702	Дотоод албан томилолт	164,900.00	400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	606,100.00	4,092,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	206,100.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,092,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,084,144.00	21,268,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		14,616,436.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,084,144.00	6,651,964.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,477,400.00	92,297,308.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,477,400.00	91,985,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,477,400.00	75,032,850.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		16,952,500.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	311,958.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		311,958.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,924,998.00	100,916,822.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,924,998.00	19,902,336.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,924,998.00	19,902,336.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,924,998.00	19,902,336.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,924,998.00	19,902,336.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,924,998.00)	(19,902,336.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	81,014,486.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		81,014,486.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	20,456,000.00	3,577,638,666.39	3,598,094,666.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,456,000.00	3,577,638,666.39	3,598,094,666.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
C07	Тайлант үеийн үр дүн			0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		-114,678,874.44	-114,678,874.44
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	20,456,000.00	3,462,959,791.95	3,483,415,791.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,456,000.00	3,462,959,791.95	3,483,415,791.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			0.00

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
D08	Тайлант үеийн үр дүн		86,079,276.92	86,079,276.92
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,456,000.00	3,549,039,068.87	3,569,495,068.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	912,934,000.00	831,607,556.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	912,934,000.00	831,607,556.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	820,834,400.00	739,622,206.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	653,334,500.00	587,448,434.00
210101	Үндсэн цалин	477,206,700.00	438,062,172.00
210102	Нэмэгдэл	146,548,500.00	119,806,962.00
210104	Урамшуулал	29,579,300.00	29,579,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,893,300.00	66,634,158.00
210201	Тэтгэврийн даатгал	55,007,300.00	44,779,562.92
210202	Тэтгэмжийн даатгал	6,471,500.00	5,338,199.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,177,100.00	4,671,699.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,294,400.00	1,168,099.61
210205	Эрүүл мэндийн даатгал	12,943,000.00	10,676,597.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,143,100.00	39,818,178.00
210301	Гэрэл, цахилгаан	12,000,000.00	11,813,029.00
210302	Түлш, халаалт	20,460,000.00	23,405,736.00
210303	Цэвэр, бохир ус	4,683,100.00	4,599,413.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	458,700.00
210604	Урсгал засвар	500,000.00	458,700.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,520,200.00	6,472,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,520,200.00	6,472,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,443,300.00	38,790,736.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,663,000.00	29,733,036.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,780,300.00	9,057,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,099,600.00	91,985,350.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,099,600.00	91,985,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	75,147,100.00	75,032,850.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,952,500.00	16,952,500.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	912,934,000.00	912,934,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	831,390,900.00	831,390,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	831,390,900.00	831,390,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	81,543,100.00	81,543,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	81,543,100.00	81,543,100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		81,014,486.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	47.00	51.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	25.00
620003	Үйлчлэх ажилтан	18.00	20.00
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		51.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	24.00	24.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	25.00	25.00
--------	--	-------	-------

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсөв аваагүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь бага боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь 2022 онд “Хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил, төлөвшил, сурлагын амжилт, чанарын ахиц гаргах багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, хяналт тавих
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
- Мэдлэг чадвараа дээшлүүлэх
- Эрүүл аюулгүй орчинд суралцах нөхцөл бүрдүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тухайлбал: Байгууллагын 2022 оны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа хангалтгүй, бараа материалын тайланг холбогдох хууль журмын дагуу гаргаагүй, цалингийн цэсэд хавсаргах анхан шатны баримтууд хангалтгүй байгаа нь дотоод хяналтын үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжсэн гэж үзэх үндэстэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургууль нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70.1 сая төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	81,014.5	81,014.49
Авлага	3,300.0	11,701.9	8,401.92
Бараа материал	12,583.2	15,714.6	3,131.32
Үндсэн хөрөнгө	3,483,556.4	3,461,064.1	(22,492.27)
Нийт хөрөнгө	3,499,439.6	3,569,495.1	70,055.45
Өр төлбөр	16,023.8	-	(16,023.83)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,483,415.8	3,569,495.1	86,079.28
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,499,439.6	3,569,495.1	70,055.45

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 81.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалин, НДШ, бараа үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсантай холбоотой ба үүнээс цалин, НДШ-ийн зардлын хэмнэлт 80.1 сая төгрөг байна.

Бараа материалын данс 3.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хангамжийн материалын орлоготой холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 8.4 сая төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант онд ажиллагсадтай холбоотой авлага нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс 22.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 19.9 сая, үнэ төлбөргүй 61.1 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 103.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд 86.1 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 86.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 835.0 сая, орон нутгийн төсвөөс 84.5 сая, нийт зарлагыг 919.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас байр ашиглахтай холбоотой зардлыг 6.6 сая төгрөгөөр бууруулж, 912.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 831.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 81.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 831.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 81.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 831.6 сая төгрөг буюу 91.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 81.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт	2,608.10	2,347.20	-260.90	90.0%
2	Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	1,304.00	650.6	-653.40	49.9%
3	Эрүүл мэндийн арга хэмжээ	2,999.30	1,110.50	-1,888.80	37.0%
4	Боловсролын арга хэмжээ	906,022.60	827,499.30	-78,523.30	91.3%
	Дүн	912,934.00	831,607.60	-81,326.40	91.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль 2022 онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 673.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 888.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 215.4 сая төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: Эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийг нийт 3.8 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан

байна. Түлш халаалтын зардал 2.9 сая төгрөгөөр хэтрэлттэй гарсан нь өмнөх оны өр төлбөрийг барагдуулахаар цалингийн зардлаас зохих зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулалт хийсэнтэй холбоотой байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илэрч албан шаардлага өгсөн. Үүнд:

1.Багш, ажилтнуудын цалинг Засгийн газрын жишиг орон тоог баримталж олгосон боловч цалин тогтоолтыг үнэн зөв хийгээгүйгээс, цалин тогтоолт, цалин бодолтод зөрүү гарч зарим багш, ажилтнуудын цалин, нэмэгдлийг илүү, дутуу тооцсон байна. Цалин тогтоолтыг зохих журмын дагуу хийгээгүй, тухай бүр тушаал шийдвэр гаргаагүй байна.

2. Тус сургууль бага боловсрол олгодог. Сургалтын үйл ажиллагаа явуулах 360 хүүхдийн хүчин чадалтай сургууль боловч Сангийн сайдын хамтарсан 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-ыг зөрчиж чиг үүрэг, орон тоог давхардуулан ажиллуулсан ба сургалтын менежерийн 1 орон тоог илүү ажиллуулж 17.2 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75%, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 61.4% байна. Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 30.4 сая төгрөгийн 4 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна.Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2022 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийсэн боловч алдаа, зөрчил илэрсэн эсэх талаар шалгаагдагч байгууллагад мэдээлэлгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өмнөх онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илэрч байсан боловч тайлант оны аудитаар зөрчлийг давтан гаргасан тул сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр хийсэн. Завсрын аудитаар цалингийн цэсэд захирал, нягтлан бодогчийн гарын үсэггүй, тамга дарж баталгаажуулаагүй, төлбөрийн хүсэлтүүдэд төрийн сангийн гүйлгээ хийснийг баталгаажуулсан гарын үсэг, тамга дарж баталгаажуулаагүй баримтууд байна. Завсрын аудитаар зөвлөгөө өгч биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үзэхэд зөрчлийг арилгаж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 518.7 сая төгрөгийн зөрчилд, боловсролын салбарын ажилтны орон тооны жишиг нормативт байхгүй хүмүүжлийн эрхлэгчийн орон тоог ажиллуулж төсвөөс 10.3 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар урсгал зардлын 10 хувиар 601.7 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй зөрчилд тус бүр 1, нийт 3 албан шаардлага, зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан зөрчилд зөвлөмж өгөгдсөн.

Өмнөх аудитын мөрөөр хүмүүжлийн эрхлэгчийн орон тоог хасаж, сургуулийн эмчид илүү олгосон цалинг төсөвт нөхөн төлүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан зөрчлүүдийг арилгаагүй, давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	623.7	1	623.7	100%
Албан шаардлага	3	529601.7	2	10901.7	66.7%
Зөвлөмж	1	719.0	0	0	0%
Нийт дүн	5	530944.4	3	11525.4	55.5%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар жил бүр давтан гаргаж байгаа зөрчлийг буюу зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй зарцуулсан эсэх, шилэн дансны мэдээллийг оруулж хэвшсэн эсэх, илүү ажиллуулж байгаа сургалтын менежерийн илүү орон тоо, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, бараа материалын тайлан гаргалтыг сайжруулсан эсэхийг хянаж үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2.9 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2.9 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг 2.9 сая, эцсийн үлдэгдлийг 2.9 сая төгрөгөөр, Санхүүгийн байдлын тайлангийн хуримтлагдсан үр дүнг 2.9 сая, тайлант оны өмнөх үеийн үр дүнг 2,9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж ирүүлсэн.

Аудитаар нийт 105.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 4.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 80.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Үдийн хоолны бараа материалаас дутагдсан материалыг тайлант оны зарцуулалтаар тайлагнасан 1.3 сая, 2021 онд шинэчлэн баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт” - ийг зөрчиж ур чадварын нэмэгдэл авсан 2.9 сая, нийт 4.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

ҮАГ-ын боловсролын ТЕЗ-д аудит хийх багаас ирүүлсэн анхаарах асуудлуудын хүрээнд шалгаж дараах зөрчлүүдийг арилгаж, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөгдлөө. Үүнд:

1. Өмнөх оноос он дамжсан 3.3 сая төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагыг барагдуулаагүй, тайлант онд шинээр 8.4 сая төгрөгийн авлага үүсгэж ажилласан байна.
2. Дээд шатны төсвийн захирагчаас удирдлагад 30 хувь, багш нарт 30 хувь, бусад албан хаагч нарт 40 хувийг олгох чиглэл өгч олгосон нэмэлт урамшууллын 40 хувийг буюу 6.8 сая төгрөгийг сургуулийн удирдлага, зарим багш нар давхардуулан илүү авсан байна.
3. Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргаж цалингийн зардлаас түлш халаалтын зардалд 3.0 сая төгрөгийг зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт: Оны эцэст цалин, НДШ-ийн зардлаас 80.1 сая төгрөгийн хэмнэлт гарсан байгаа нь хүчин чадлаас хэтэрсэн хүүхдийн тоогоор санхүүжилт авсан гэж үзэх үндэслэлтэй

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ба энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн ба АОУС-250-д "Санхүүгийн тайланд хууль тогтоомж, дүрэм, журмыг анхаарах", АДБОУС 200 болон нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, төсвийг бодитой төлөвлөх;

2. Илрүүлэлт:

Ур чадвар олгох шалгуур үзүүлэлтийн дагуу хагас жил тутамд сургуулийн захирал нь шалгуур үзүүлэлтэд заасны дагуу хамт олны оролцоог хангаж багш, ажилтны ур чадварыг үнэлж байх ёстой боловч хэрэгжүүлээгүй байгаа нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийг зөрчсөн ба АОУС-250-д "Санхүүгийн тайланд хууль тогтоомж, дүрэм, журмыг анхаарах", АДБОУС 200 стандартууд болон үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварын үнэлгээг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-д заасны дагуу хийх;

3. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй, бараа материалын журналын хөтлөлт хангалтгүй, нярав хоолны материалын тайланг үнэн зөв гаргаагүй нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх", 14.3.2-т "журналд бичих", 14.3.3-т "дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх;", 14.3.4-т "ажил, гүйлгээний мэдээ гаргах" гэсэн заалтуудыг зөрчсөн ба АОУС-250-д "Санхүүгийн тайланд хууль тогтоомж, дүрэм, журмыг анхаарах", УСНББОУС-1, АДБОУС 200 стандартууд болон үнэн зөв, иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулж, бараа материалын журналыг зохих ёсоор тухай бүр хөтөлж, нярав аж ахуйн тайланг үнэн зөв гаргаж, илэрсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх;

4.Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, сургуулийн удирдлага болон нягтлан бодогч нь санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар ойлголт, мэдээлэлгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай нийцээгүй, АОУС-250-

д "Санхүүгийн тайланд хууль тогтоомж, дүрэм, журмыг анхаарах", УСНББОУС-1, АДБОУС 200 болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ашиглах, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаарх мэдээлэл, ойлголтоо сайжруулах;

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	2965.9			1	2965.9	1	2965.9				
Дүн	1	2965.9			1	2965.9	1	2965.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үдийн хоолны материалыг дутагдуулсан	1	1268.2	1	1268.2								
Шалгуур үзүүлэлт хангаагүй ур чадварын нэмэгдэл авсан	1	2983.7	1	2983.7								
Зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан	1	2945.7			1	2945.7						
Ажилтнуудын ур чадварыг үнэлээгүй	1						1					
Өмнөх оноос он дамжсан 3.3 сая төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагыг барагдуулаагүй, тайлант онд шинээр 8.4 сая төгрөгийн авлага үүсгэж	1	11701.9			1	11701.9						
Нэмэлт урамшуулал олгох дээд шатны ТЗ-ийн ирүүлсэн чиглэлийг зөрчиж 6.8 сая төгрөгийг сургуулийн	1	6781.0			1	6781.0						

удирдлага, зарим багш нар давхардуулан илүү авсан байна.												
Хүчин чадлаас хэтэрсэн хүүхдийн тоогоор санхүүжилт авсан	1	80145.2					1	80145.2				
Нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй	1						1					
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, сургуулийн удирдлага болон нягтлан бодогч нь санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар ойлголт, мэдээлэлгүй	1						1					
Дүн	9	105825.7	2	4251.9	1	21428.6	4	80145.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 4 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна	1	30424.0			1	30424.0		
Дүн	1	30424.0			1	30424.0		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цалин тогтоолтыг зохих журмын дагуу хийгээгүйгээс цалингийн нэмэгдлүүдийг илүү, дутуу тооцож олгох явдал гарсан байна	1				1			
Чиг орон тоог давхардуулж сургалтын менежерийн 1 орон тоог илүү ажиллуулсан.	1	17186.2			1	17186.2		
Дүн	2	17186.2			1	17186.2		
Нийт дүн	3	47610.2			2	47610.2		